



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/28

Улаанбаатар хот

Зочид буудал, дэн буудлын үйл  
ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох,  
хүчингүй болгох тухай

Монгол Улсын Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид Зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан иргэн, аж ахуйн нэгжид Дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Амралтын газарт тавигдах ерөнхий шаардлага MNS6043:2009” стандартын шаардлагыг хангасан, тушаалын гуравдугаар хавсралтад дурдсан аж ахуйн нэгжид жуулчны баазын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Монгол угсаа дөвөлөмт ХХК-ийн “Юу би сүйтэс хотел” зочид буудлын 17/066, Актив партнерс ХХК-ийн “Парк хотел” зочид буудлын 17/057, Харцад ХХК-ийн “Нийслэл” Зочид буудлын 17/076, Тунамал алтан зоос ББСБ-ийн “Стар” зочид буудлын 17/044, Монгол овоо ХХК-ийн “Прогресс” зочид буудлын 17/058, Юу би ай эн эн ХХК-ийн “Юу би ай эн эн” зочид буудлын 17/048, Хаан шонхор ХХК-ийн “Хаан шонхор” дэн буудлын 17/077, Хүрд нарлаг ХХК-ийн “Барилгачин” амралтын газрын 17/055 тоот гэрчилгээг хүчингүй болсонд тооцсугай.

5. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

115 530095

6. Энэхүү тушаалыг Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газар, Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Үйлчилгээний байгууллага, стандарт хариуцсан мэргэжилтэн /Б.Амар/-д үүрэг болгосугай.

7. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг байгууллага болон иргэн тус бүрээс хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батбаатар/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 04 сарын 18  
өдрийн А28 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

1118139265  
УОА0453 5284325

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.04.18

Улаанбаатар хот

Д/Д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Монгол угсаа девелопмент ХХК	6116914	Юу би сүйтэс хотел	БЗД-ийн 2-р хороо Б.Доржийн гудамж
2	Актив партнерс ХХК	5621798	Парк хотел	БЗД-ийн 4-р хороо Лхагвасүрэнгийн гудамж 32
3	Харцад ХХК	2671026	Нийслэл	БЗД-ийн 5-р хороо 15-р хороолол ЭТӨЧ 63
4	Тунамал алтан зоос ББСБ	5272459	Стар	БГД-ийн 12-р хороо Хасбаатарын гудамж 6-1
5	Монгол овоо ХХК	2801418	Прогресс	БГД-ийн 5-р хороо 10-р хороолол ЭТӨЧ 58
6	Юу би ай эн эн ХХК	5571251	Юу би ай эн эн	ЧД-ийн 5-р хороо Самбуугийн гудамж 35

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын даргын 2018 оны 04 сарын 18  
өдрийн А28 дугаар тушаалын  
хоёрдугаар хавсралт

1117339265  
УОА0453 5284325

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.04.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хаан шонхор ХХК	2581289	Хаан шонхор	БЗД-ийн 18-р хороо 13-р хороолол 45
2	Жинс цачирт ХХК	5254736	Есөн ембүү	СХД-ийн 27-р хороо Баянхошуу 15-1
3	Ийгл дуудлага сервис ХХК	5546109	Саруул	СБД-ийн 8-р хороо АНУ төвийн 3 давхарт

-ooOoo-

Нийслэлийн Аялал жуулчлалын  
газрын дарын 2018 оны 04 сарын 18  
өдрийн 428 дугаар тушаалын  
гуравдугаар хавсралт

1117339265  
УОА0453 5284325

АМРАЛТЫН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ  
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН  
ЖАГСААЛТ

2018.04.18

Улаанбаатар хот

Д/д	Иргэн, аж ахуйн нэгжийн нэр	Эзэмшигчийн регистрийн дугаар	Оноосон нэр	Байршил
1	Хүрд нарлаг ХХК	2797399	Барилгачин	СБД-ийн 9-р хороо их сургуулийн гудамж 9
2	Өнөр бсоб ХХК	2677741	Домогт мэлхий хад	НД-ийн 6-р хороо Мэлхий хад 1

-ooOoo-